

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 6-Р ХОРООНЫ НУТАГ
ДЭВСГЭРТ ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ
ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ “МӨНХ АРИУН УНДАРГА” ХХК-ИЙН
“САЦ” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1. Төслийн нэр	3
1.2. Төсөл хэрэгжүүлэгч	3
1.3. Төслийн зорилго	3
1.4. Төслийн хүчин чадал	3
Төслийн талбайн байршил	4
1.5. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил	5
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
2.1. Физик газарзүй	6
2.2. Цаг уур, уур амьсгал	7
2.3. Гадаргын болон гүний ус	7
2.4. Хөрсөн бүрхэвч	7
2.5. Ургамлан нөмрөг	7
2.6. Амьтны аймаг	8
2.7. Нийгэм, эдийн засаг	8
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
3.1.1. Байгаль орчны үнэлгээний нэгтгэл	10
3.2. Төслийн гол сөрөг нөлөөллийг тодорхойлох	10
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО	12
4.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	12
4.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
4.1.2. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	13
4.1.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	13
4.1.4. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	13
4.2. Төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	13
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
5.1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
5.1.1. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	19
5.1.2. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	19
5.1.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
5.1.4. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	19
5.2. Осол, эрсдэлийн төлөвлөгөө	20
5.3. Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	21
5.4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	23
5.5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө	25
5.6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал	26
6. ДҮГНЭЛТ	27

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Барилга байгууламжийн үндсэн хүчин чадал	3
Хүснэгт 2. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрчим, түүний үнэлгээ	10
Хүснэгт 3. Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр	11
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
Хүснэгт 6. Осол, эрсдэлийн төлөвлөгөө	20
Хүснэгт 7. Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	23
Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө	25

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил	4
Зураг 2. Төслийн талбайн тоглоомын талбайн зураг	4
Зураг 3. Төслийн талбайн уурын зуух	5
Зураг 4. Төслийн талбай орчмын зам харилцаа	5
Зураг 5. Төслийн талбайн өндөржилт болон налуу	6
Зураг 6. Төслийн нөлөөллийн бүсэд байрлах байгууллага	8
Зураг 7. Орчны хяналт шинжилгээний цэгүүд	14

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Сац аялал жуулчлалын бааз” төсөл

1.2. Төсөл хэрэгжүүлэгч

Төсөл хэрэгжүүлэгч: “Мөнх Ариун Ундарга” ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9011156052
Регистрийн дугаар: 5235359
Хаяг: Улаанбаатар, Баянгол дүүрэг, 3-р хороо, 2-р хороолол 5-53
Холбоо барих утас: 91771111, 99099069

1.3. Төслийн зорилго

“Мөнх ариун ундарга” ХХК-ийн “САЦ” жуулчны бааз нь олон улсын түвшинд нийцсэн үйл ажиллагаа явуулах, улс орныхоо аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах, үйлчилгээний соёлыг дээд зэргээр ханган, амьдралын баталгааг сайжруулж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн, ажлын байрыг нэмэгдүүлснээр эдийн засагт бодит хувь нэмэр оруулахад оршино.

1.4. Төслийн хүчин чадал

Төсөл нь нийт 1.0 га талбайд хэрэгжих бөгөөд Сац аялал жуулчлалын бааз нэг ээлжиндээ 140 хүн хүлээж авах ба нийт 22 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулна. “Сац аялал жуулчлалын бааз” төслийн барилга байгууламж:


- 3 давхар бүхий барилга байгууламжтай (зоорийн давхартай)
- 1 давхар -гал тогоо, хоолны танхим 140 хүн нэгэн зэрэг хүлээн авна, нийтийн, биз засах газар, биллярд өрөө-1, караоке-2, хүүхдийн тоглоомын өрөө-1, хурлын заал-40 хүн хүлээн авах, сувенирийн өрөө, хүлээлгийн хэсэг
- 2 давхарт- оффис өрөө-1, зочин хүлээн авах өрөө 17, нийт 34 хүн хүлээн авах хүчин чадалтай
- 3 давхар-10 өрөө нийт 20 хүн хүлээн авах хүчин чадалтай
- Өрөө нийт 27 өрөө нэгэн зэрэг 54 хүн хүлээн авах хүчин чадалтай
- Зоорийн давхарт-угаалгын өрөө, ажилчдын байр-2, усны нөөцийн өрөө, шит, узелийн өрөө, 10 машин тавих зогсоол
- Авто зогсоол бүхий угтах хэсэг
- Хүүхдийн тоглоомын талбай
- Хүүхэд залуучуудын иж бүрэн цогцолборт тоглоомын талбай
- Цэцэрлэгт хүрээлэн бүхий амралтын байр, саравч
- 16 ширхэг модон байшингууд
- Орчин үеийн усан оргилуур бүхий цэцэрлэгт хүрээлэн
- Усан сан

Хүснэгт 1. Барилга байгууламжийн үндсэн хүчин чадал

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	Барилгын эзлэхүүн	м.куб	7560	
2	Ашигтай талбай	кв.м	1865.35	
4	Дулаан авто зогсоол	кв.м	392.13	10 машин
6	Хүчин чадал	кв.м		140 хүн
7	Давхрын тоо	кв.м	507.95	зоорьтой, 3 давхар
9	Өдрийн амрагчийн орны тоо	ор	54	
10	Хүүхдийн тоглоомын өрөө	ор	35	
11	Нийт эдэлбэр газрын хэмжээ	кв.м	10000	
12	Барилгажилтын талбай	кв.м	540	
13	Хооллох заал	кв.м	149.25	140 хүний багтаамжтай,
14	Амралтын жижиг сууц	кв.м		16 ш

Төслийн талбайн байршил

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд 1.0 га талбайд хэрэгжиж байна.



Зураг 1. Төслийн талбайн байршил



Зураг 2. Төслийн талбайн тоглоомын талбайн зураг

1.5. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил

Цахилгаан хангамж: Ойролцоох эрчим хүчний шугамаас хангадаг.

Дулаан хангамж: Төслийн дулаан хангамжийг утааны усан шүүлтүүртэй байгаль орчинд ээлтэй уурын зуухаар хангадаг.



Зураг 3. Төслийн талбайн уурын зуух

Цэвэр усны хангамж: Төслийн талбайд гаргасан гүний өрөмдмөл худгаас хангадаг.

Харилцаа холбоо: Холбоо мэдээллийн хувьд бүх үүрэн телефон холбоо ашиглах боломжтой. Гар утас, интернэтэд холбогдсон.

Зам харилцаа: Улаанбаатар хотоос зүүн зүгт Арагант хүртэл 53 км засмал замаас салаад 430 орчим метр хайргаар хучиж сайжруулсан замаар явж хүрнэ.



Зураг 4. Төслийн талбай орчмын зам харилцаа


2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Физик газарзүй

Төсөл нь Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хязгаарлалтын бүсэд хэрэгжиж байна. Төсөл хэрэгжих талбайн орчимд нугат хээрийн болон хээрийн ландшафт тархсан байна.

Горхи-Тэрэлжийн БЦГ нь Хэнтийн районд хамрагдах бөгөөд ян сарьдаг, уулын таг, уулын тайга, уулын хээр, намагт нугын ландшафт хослон оршдог боловч уулын тайгын ландшафт гадаргын ихэнх хэсэгт тархжээ.

Уулын тагийн ландшафт: Уулын тагийн ландшафт нь 2100 м-ээс 2400 м өндөрт тохиолддог. Гадарга нь уулсын оройн хэсэгт тэгшивтэр, хажуу нь эгц байдалтай, асга хадаар 70-80% бүрхэгдсэн байдаг. Энэ хэв шинжийн ландшафт Хэнтийн гол нуруу, түүний салбар, Их, Бага Хэнтийн нурууны төв хэсэг, тэдгээрийн орой хярын тэгш хавтгай гадарга, хад асга бүхий эгцэвтэр хажуугаар зонхилно.



Зураг 5. Төслийн талбайн өндөржилт болон налуу

2.2. Цаг уур, уур амьсгал

Горхи-Тэрэлж орчмын дэвсгэр гадаргуугийн өвөрмөц нөхцөл нь бүс нутгийн уур амьсгал бүрэлдэн тогтох нэгэн хүчин зүйл болдог. Өөрөөр хэлбэл, Хан Хэнтийн нурууны их уулс нь Монгол орны төдийгүй Төв Азийн уур амьсгал бүрэлдэхэд нөлөө бүхий Сибирээс их говь руу уртрагийн дагуу түрж тогтсон өвөрмөц онцлогтой. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Уур амьсгалын үзүүлэлтүүд нь тэгш хэмийн хуваарилалттай. Хаврын дулааралт, намрын сэрүүсэлтийн явц ижилхэн, зундаа сэрүүн чийглэг, өвөл нь хүйтэн чийглэг болдог. Монгол орны бусад нутгаас хамгийн их хур тунадастай, чийглэг, сэрүүн, өвөл нь цасархаг харьцангуй дулаавтар тунгалаг цэнгэг агаартай зэрэг онцлог бий.

Горхи-Тэрэлж орчим нь Монгол орны уур амьсгалын мужлалаар чийглэг хүйтэн зуны бүс (I) болон чийглэгдүү хүйтэвтэр зуны бүс (II) нутгийг хамарч, хахир өвлийн мужид хамрагддаг

2.3. Гадаргын болон гүний ус

Төсөл хэрэгжих талбай нь гадаргын усны сүлжээний хувьд Хойд мөсөн далайн ай савд хамаарах бөгөөд Тэрэлж голын сав газарт багтана. Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд гадаргын урсац байхгүй.

Газар доорх ус орших байдлаараа нүх сүвний, ан цавын гэсэн үндсэн 2 хэв шинжид хуваагддаг. Гидродинамикийн горимын хувьд янз бүрийн настай чулуулаг дахь ан цавын ус голдуу шахалтгүй нөхцөлд оршино. Газрын доорх усны нөөц маш жигд биш тархацтай. Газрын доорх ус хуримтлагдах нөхцөл хур тунадасны хэмжээ, конденсац үүсэх нөхцөл, тектоник хагарлын байршил, ялангуяа томоохон хагарлаас ихээхэн хамаарна. Улаанбаатар хотын газрын доорх усны ай сав уулс хоорондын артезийн ай сав бөгөөд гадаргын болон газрын доорх усны өвөрмөц холбоог үүсгэдэг бэсрэг хэмжээтэй боловч усны харьцангуй арвин нөөцтэй. Энэхүү ай савд Хойд туйлын, Урд туйлын гэсэн 2 томоохон репюналь хагарал байдгийг геологичид зураглан тогтоосон байна. Уг ай савыг хүрээлэн байгаа уулс нь газрын доорх усны тэжээлийн бүс, Улаанбаатарын хотгор нь хуримтлал зөөгдөл, хөлийн бүс болдог.

2.4. Хөрсөн бүрхэвч

Горхи-Тэрэлж орчмын газар нутаг нь хөрс-газарзүйн мужлалаар Хангайн био уур амьсгалын их мужийн өндөршлийн бүсчлэл бүхий Хэнтийн тойрогт багтана. Хэнтийн уулсын хөрс нь Хангай, Хөвсгөл, орчмын хөрснөөс ялгагдах өвөрмөц онцлогтой. Харьцангуй нам доор газарт орших учраас дулааны улирлын хугацаа урт байх бөгөөд хөрсөн дэх органик хуримтлал Хангай, Хөвсгөлийн уулсын хөрснөөс арай илүү байна. Илүү чийглэг нөхцөлтэй, хүйтэн өдрийн үргэлжлэх хугацаа арай бага зэргээс шалтгаалж хөрс нь харьцангуй илүү чийглэг, органикийн агууламж өндөр, намгархаг хэв шинжийн хөрс илүү тархсан зэрэг онцлогтой.

2.5. Ургамлан нөмрөг

Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Горхи-Тэрэлж орчмын нутаг дэвсгэр нь Хэнтийн уулын тайгын тойрог, Монгол дагуурын уулын ойт хээрийн тойрог гэсэн 2 тойргийн уулзвар нутагт байрладаг.

Тэрэлж гол, түүний татмаар 36 овогт хамаарах 109 төрлийн 183 зүйл бүртгэгджээ. Тэрэлж голын дагуу Бушилз-бургас, боролзгоно бүхий аллюви-пролювийн, Шинэс-боролзгонот, Улиас боролзгонот, Улалжит-намагшсан, Хөвд-хөвөн оройтот, Хөвд-улалжит, Бургасан шугуй бүхий, Ширэг улалж бүхий хээржсэн татмын ургамалжилтын хэв шинж тархана.

Төслийн талбай орчимд буюу Тэрэлж голын татмын 1529 м-т алаг өвс-улалж-түнгэт нугын бүлгэмдэлд 100 м² талбайд 20 орчим зүйл ургамал бүртгэгдсэн байна. Тусгагын бүрхэц нь 60-65 хувь, ургамлын дундаж өндөр 12 см.


2.6. Амьтны аймаг

Төсөл нь Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хязгаарлалтын бүсэд хэрэгжинэ. Төсөл хэрэгжих талбай орчимд аялал жуулчлал ихээхэн хөгжсөн бүс нутаг тул суурьшил болон хүн амын хөдөлгөөн ихэссэний улмаас тэр орчмын хөхтөн амьтад нутаг сэлгэсэн, дайжсан гэх ба ойт хээр, тайгын бүс бүслүүрт амьдардаг хөхтөн амьтад тохиолдлоор үзэгддэг байна. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланд төсөл хэрэгжих талбай орчмын амьтны аймгийн онцлогийг Горхи-Тэрэлжийн БЦГ-ын амьтны аймгийн онцлогоор төлөөлүүлэн авав.

Горхи-Тэрэлжийн БЦГ-т Монгол орны хэмжээнд ховордож, Монголын улаан номд бүртгэгдсэн *дагуур зараа* /*Mesechinus dauricus*/ (Шийрэвдамба нар, 1997), *халиун буга* /*Cervus elaphus*/, нэн ховор зүйлд орох *баданга хүдэр* /*Moschus moschiferus*/, хууль бус агналтын улмаас тоо толгой, тархац нутаг нь багасаж байгаа агнуурын ач холбогдолтой *монгол тарвага* /*Marmota sibirica*/, *бараан хэрэм* /*Sciurus vulgaris*/ зэрэг амьтад тархана.

2.7. Нийгэм, эдийн засаг

Налайх дүүргийн 6-р хороо нь хойд талаараа Төв аймгийн Эрдэнэ сумын Баянтуулын 3 дугаар баг, баруун талаараа Баянзүрх дүүргийн Гачуурт тосгон, зүүн болон урд хэсгээрээ дүүргийн 1,5 дугаар хороотой тус тус хиллэдэг. Хорооны төвөөс 5-25 км-т алслагдсан 379 өрх оршин суудаг. Хорооны нутаг дэвсгэрт төрийн байгууллага- 6, ХААН банк, 100 гаруй амралт, аялал жуулчлалын бааз, Хүнсний дэлгүүр, минимаркет 9, Зочид буудал- 4 зэрэг ААНБ-ууд байрлан үйл ажиллагаагаа явуулж байна. **Хүн ам зүй (эзлэх хувь)**- Налайх дүүргийн 6 дугаар хороо 2019 онд 1493 мян хүн амтай байсан бол 2023 оны байдлаар 1659 болон өссөн байна. Нийт хүн амын 878 буюу 51,7%-ийг эрэгтэй, 818 буюу 48,2%-ийг эмэгтэй хүмүүс эзэлж байна. **Төслийн талбайн орчин тойрон**- Налайх дүүрэгт 2024 оны 1-р улирлын байдлаар 711 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас, 220 байгууллага үйл ажиллагаа эхлээгүй, 621 түр зогссон, 35 бүрэн зогссон аж ахуйн, нэгж байгууллага байна. Үүнээс “Мөнх ариун ундарга” ХХК Сац эко аялал жуулчлалын баазын нөлөөллийн бүсэд газар ашиглалтын аялал жуулчлалын баазын төрөл бүхий нэг газар байна.



Зураг 6. Төслийн нөлөөллийн бүсэд байрлах байгууллага

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд “Мөнх Ариун Ундарга” ХХК-ийн “Сац аялал жуулчлалын бааз” төслийн танилцуулга болон бусад холбогдох бичиг баримтыг нарийвчлан судалж, төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг засгийн газрын 2023.02.08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын дагуу дараах аргачлалд заасан нөлөөллийн эх үүсвэр, тэдгээрт өртөгдөх байгаль, нийгэм, эдийн засгийн хам бүрдлийг тодорхойлох “Магадлан жагсаах” (checklist), болон “Леопольдын матрицын арга”, нөлөөлөл буурах функц ArcGIS 10.3 программын “MDT” түүлс ашиглан тодорхойлов. Дээрх сөрөг нөлөөллийг тодорхойлсны үндсэн дээр үйлдвэрийн технологийн болон үйл ажиллагааны менежментийн хувьд хэрэгжүүлэх боломжтой шийдэл зөвлөмжийг боловсруулсан болно.

Төслийн орон зайн хамрах хүрээ нь шууд болон шууд бус нөлөөллийн бүсээр Төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байгалийн хам бүрдэл тус бүрийн хувьд авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Агаар орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл:

Тус төслийн үйл ажиллагаанаас агаарын орчинд үзүүлэх гол нөлөөлөл нь дараах эх үүсвэр (үйл ажиллагаанаас)-ээс хамаарч байна. Үүнд:

- Ажилчид болон ойролцоох зам дагуу зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс үүсэх тоосжилт, хийн бохирдуулагч ялгарах, дуу чимээ үүсэх
- Төслийн талбайн дахь уурын зуух
- Хатуу хог хаягдлын задралаас агаарт бохирдуулагч бодис тархах

Нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ:

- Төслийн эдэлбэр газар, зам талбайн төлөвлөлтийг хийж, орчны тохижилт, ногоон байгууламж талбайг нэмэгдүүлэх.
- БОННУ-ний тайлангийн “Хог хаягдлын менежментийн зөвлөмж”-ийг хэрэгжүүлж ажилласнаар агаар орчин бохирдохоос сэргийлнэ.
- Хог хаягдлыг битүү байр, саванд цуглуулж түр хадгалах, хог хаягдлын цэгт зөөж зайлуулах.

Усан орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл:

Төсөл хэрэгжих талбай нь гадаргын усны сүлжээний хувьд Хойд мөсөн далайн ай савд хамаарах бөгөөд Тэрэлж голын сав газарт багтана. Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд гадаргын урсац байхгүй.

Нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ:

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хаягдал бохир усанд химийн шинжилгээг тогтмол хийлгэж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан ажиллаж байх.
- Ажилчдын унд-ахуйн усны чанарт хяналт тавих

Хөрсөн бүрхэвч, эдэлбэр газарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

Төслийн талбай нь Улаанбаатар хот нутаг дэвсгэр нь хөрсний газарзүйн мужлалаар (Доржготов Д., УБ 1984, 1994). Улаанбаатар хот хөрс-био уур амьсгалын Хангайн их мужийн Хэнтийн өмнөх тойрогт багтах бөгөөд Монгол орны хөрсний ангиллаар тал

газар, хөндий хотгорын хөрсний бүлэгт багтах ба судалгааны талбайд хар хүрэн хөрс тархсан байна.

Төсөл хэрэгжих үеийн хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх болзошгүй нөлөөлөл нь:

- Шатах тослох материал, ахуйн хатуу, шингэн хог хаягдлаар хөрс бохирдох болно.

Нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ:

- Хөрс бохирдохоос сэргийлэх, хатуу хог хаягдлыг эрүүл ахуйн нөхцөлийг хангасан цэгт түр хадгалан, зөөвөрлөж тогтоосон цэгт зайлуулж байх.

Төслийн талбайн авто зогсоол, хог хаягдлыг зайлуулах талбайг сайжруулах, засаж тохижуулах.

3.1.1. Байгаль орчны үнэлгээний нэгтгэл

“Мөнх Ариун Ундарга” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Сац” аялал жуулчлалын бааз төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг өмнөх хэсэгт авч үзсэнийг нэгтгэвэл 20 үзүүлэлтээр нөлөөллийн эрчмийг тодорхойлсноос төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн нөлөөллийн 25.0% нь нөлөөлөлгүй, 50.0% нь бага, 25.0% дунд нөлөөлөлтэй байна. Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчим байгаль орчны бусад бүрдэл хэсгүүдээс их байна.

Хүснэгт 2. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрчим, түүний үнэлгээ

№	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэг					Үнэлгээ	
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их	Сүйрлийн	Тоо	Хувь
1	Эдэлбэр газарт үзүүлэх нөлөө	1	2	1	0	0	4	20.0
2	Агаарын чанарт үзүүлэх нөлөө	0	3	2	0	0	5	25.0
3	Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөө	2	2	0	0	0	4	20.0
4	Ургамал, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө	0	1	1	0	0	2	10.0
5	Амьтны аймагт үзүүлэх нөлөө	0	2	1	0	0	3	15.0
6	Нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөө	2	0	0	0	0	2	10.0
Нөлөөллийн эрчим		5	10	5	0	0	20	100.0
		25.0	50.0	25.0	0.0	0.0	100.0	

3.2. Төслийн гол сөрөг нөлөөллийг тодорхойлох

“Мөнх Ариун Ундарга” ХХК-ийн “Сац аялал жуулчлалын бааз” төслийг хэрэгжүүлэхэд хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлсон үр дүнд үндэслэн нөлөөллийн эх үүсвэр, шинж чанарыг тодорхойлж дараах хүснэгтэд үзүүлэв.

Өмнө нь хийгдсэн болзошгүй нөлөөллийн судалгааны дүнгээс үзвэл жуулчны баазын төслөөс байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь:

1. Ахуйн шингэн хаягдлыг зайлуулах технологийн горимыг баримтлаагүй тохиолдолд газрын гүний болон хөрсний ус бохирдож улмаар гадаргын усны чанарт сөргөөр нөлөөлөх.
2. Хатуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулах журам, дэглэм, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хөрс болон агаар орчныг бохирдуулах.
3. Машин тээврийн хэрэгсэл, хөдөлгөөн ихсэх, олон салаа зам гаргах зэргээс хөрс элэгдэл эвдрэлд орох, дагтарших.
4. Төслийн талбай дахь уурын зуух. Хийн хаягдал
5. Хүний хөдөлгөөн ихсэх, түр хугацааны жим, зам гарах, анхаарал болгоомжгүйгээс ой хээрийн түймэр гарах зэрэг нь ургамлан бүрхүүлд нөлөөлөн,

түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж /хогийн ургамал ихсэх/, ургац муудах магадлалтай.

6. Жуулчны баазын дуу чимээний нөлөөллөөс шалтгаалан ойр орчмын амьтад дайжиж болно.

Хүснэгт 3. Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар
<i>Агаар орчин</i>			
1	Тоосжилт	- Хүмүүсийн хөл - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн	- Улирлын чанартай. - Тархах хүрээ хязгаарлагдмал. - Амархан сарнина.
2	Утаа, Угаар	- Уурын зуух - Тээврийн хэрэгсэл	- Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал.
<i>Усан орчин</i>			
3	Хатуу болон шингэн хаягдал	- Ахуйн хог хаягдал - Шатах тослох материалын хаягдал	- Гадаргын ус бохирдоно. - Хөрс болон хөрсний ус бохирдох магадлалтай. - Удаан сарнина.
4	Усны нөөцийн хомсдол	- Унд ахуйн усны хэрэглээ	- Шууд бус дам нөлөө үзүүлнэ
<i>Хөрсөн бүрхэвч</i>			
5	Элэгдэл, эвдрэл	- Зориулалтын бус замаар явснаар явган жим, зам гарах, хөрс дагтарших, талхлагдах	- Тархалтын хүрээ хязгаарлагдмал. - Тархалтыг хязгаарлах боломжтой. - Нөхөн сэргээх боломжтой. - Шинж чанар өөрчлөгдөнө.
6	Бохирдол	- Ахуйн, шингэн хог хаягдал - Шатах тослох материалын асгаралт - Бохир ус дамжуулах шугам хоолойн гэмтэл, доголдол	- Тархах хүрээ хязгаарлагдмал. - Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана.
<i>Ургамал бүрхэвч</i>			
7	Ургамлан нөмрөг талхлагдах	- Хүний хөл хөдөлгөөн, үйл ажиллагаанд байнга өртөж буй зам, жим - Ашиглалтын талбай, барилга байгууламжийн орчимд	- Хэмжээ хязгаарлагдмал. - Тухайн орчны ургамлан нөмрөг багасах, төрөл зүйл хомсдож болно. - Ургамалжуулалт хийснээр нөхөн сэргээх боломжтой.
8	Бохирдол	- Ахуйн хог болон шатах тослох материалын хаягдал	- Ургамлын биомассын хэмжээ багасна. - Ургамлын бүрэлдэхүүнд өөрчлөлт орж болзошгүй.
<i>Амьтан</i>			
9	Үргэн, дайжих	- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн - Дуу чимээ	Тухайн орчинд амьдрах боломжгүй болж дайжих
10	Бохирдол	- Хог хаягдал - Шатах тослох материалын асгаралт	- Тархалтын хүрээ хязгаарлагдмал - Хөрсөн дэх бичил биетэн, шавж хорхой үрэгдэж болно. - Ашиггүй бичил биетэн үржих.
<i>Нийгэм-эдийн засгийн орчин</i>			
11	Амрагч, сувилуулагчдын алжаалыг тайлах	- Хүн амын эрүүл мэнд, ажил эрхлэх чадавх дээшилнэ.	Хүн амын эрүүл мэндэд эерэг нөлөө их.
12	Үндсэн хөрөнгө	- Татварын эх үүсвэр	Улсын төсөвт хувь нэмэр оруулна.
13	Шинэ ажиллагсад авна.	- Ажлын байр шинээр бий болно.	Орон нутгийн иргэд орлогын тогтмол эх үүсвэртэй болно.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-д зааснаар “Мөнх Ариун Ундарга” ХХК-ийн “Сац аялал жуулчлалын бааз” төсөл нь тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.
- Ажилчид байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа ойлгосон байх, сургалтад хамрагдах боломжтой болно.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцсоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.
- Сум орон нутгийн удирдлага, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

4.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Хими-микробиологийн лаборатори”-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах баримт бичиг юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОУАӨЯ-наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагуудтай уялдуулан боловсруулсан ба тэдгээрийн хэрэгжилтийг 5 жилийн хугацаанд буюу 2025 оноос 2029 оны хугацаанд төлөвлөв. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй. БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн

тайланг тухайн оны 12 сарын дотор БОУАӨЯ-нд ирүүлж, мөн орон нутгийн засаг захиргааны байгууллага, хорооны иргэдэд танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

4.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Мөнх Ариун Ундарга” ХХК-ийн “Сац аялал жуулчлалын бааз” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл “бага” эрчимтэй боловч үйл ажиллагаанаас гарах ахуйн шингэн хаягдал, хатуу хог хаягдлаас үзүүлэх нөлөөлөл, хөрс, ургамал, газрын доорх ус болон бусад хам бүрдэлд үзүүлэх нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арилгах, бууруулах үүднээс төслийг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

4.1.2. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргадаг ба уг төслийн хувьд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй болно.

4.1.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайд түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сумын засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай.

4.1.4. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Энэхүү төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд тусгалаа.

4.2. Төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Мөнх ариун ундарга” ХХК-ийн аялал жуулчлалын баазын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамруулан байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн системийг байгуулах нь зүйтэй.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” /ОХШХ/ гэнэ. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

Агаар орчин

ОХШХ-т тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж, дүгнэлт

гаргуулж байх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авна. Хийн бохирдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амрагч, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байх ёстой буюу төлөвлөлтийн холбогдох үндсэн шалгуурууд агаарт хаяж буй бохирдуулагчдад тавигдах ёстой.

Усны чанар

Усны чанарын шинжилгээг төсөл хэрэгжих хугацаанд хийлгэх хяналт шинжилгээг графикт хугацаанд нь шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан, бохирдол илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран түүнийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөрсөн бүрхэвч

Хөрсний бохирдлын түвшинг дотоодын магадлан итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрт тогтоосон сорьц авах цэгүүд дээр үргэлжлүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.



Зураг 7. Орчны хяналт шинжилгээний цэгүүд

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Мөнх Ариун Ундарга” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Сац аялал жуулчлалын бааз” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл “бага” эрчимтэй боловч үйл ажиллагаанаас гарах ахуйн шингэн хаягдал, хатуу хог хаягдлаас үзүүлэх нөлөөлөл, хөрс, ургамал, газрын доорх ус болон бусад хам бүрдэлд үзүүлэх нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арилгах, бууруулах үүднээс төслийг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, төг	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэл-тийн шалгуур Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ									
Хийн хаягдал, тоосжилт	Орчны агаараас сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах	Агаарын чанар	2 цэгт		ОХШХ-Т Тусгагдсан		“Мөнх ариун ундарга” ХХК	Жилд 2 удаа	Агаарын тухай хууль, Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр MNS ISO 4227:2002 MNS ISO 4226:2000 MNS 4585:2016
	Төслийн талбай дахь ногоон байгууламжийн аричлгаа, тордлогоо	Төслийн талбайд	0.2 га-аас багагүй талбайд		400.000				
Гадаргын болон газрын доорх ус нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ									
Усны нөөц, хэрэглээ	Усны төлбөр төлөх	Усны нөөц хэмнэх	багц		-		“Мөнх ариун ундарга” ХХК	Сар бүр	
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ									
Хөрс, хөрсөн бүрхэвч бохирдох	Байгаль орчинд ээлтэй эко ариун цэврийн байгууламжийн бохирыг тогтмол соруулах	Хөрсөн бүрхэвч	багц		Үйл ажиллагааны зардалд		“Мөнх ариун ундарга” ХХК	Төсөл хэрэгжих хугацаанд	MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ									
БОННУ-ний тайлангийн БОМТ-ны хэрэгжилтийн талаар нутгийн иргэдэд тайлагнах		Олон нийтийн оролцоо, хяналтыг	багц	-	-	-	“Мөнх ариун ундарга” ХХК	ИНХ-ын дарга	БОНХЯ-ны сайдын 2014.01.06-ны өдрийн А-03 тоот журам

	хэрэгжүүлэх хүрээнд							
Нийт :400,00								

5.1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, өртөгч	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээн ий цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (.төг)	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө									
	Гадаад талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах	Баазын хашаанд	1ш	2,500,000	2,500,000	“Мөнх ариун ундарга” ХХК			Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл” “Хог хаягдлын тухай хууль”, Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр, БОАЖ сайдын 2018.11.17 өдрийн А/443 дугаар тушаал Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах,гэвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага
	“Хог хаягдлын гэрээ” байгуулан, гэрээний дагуу хог хаягдлыг төвлөрсөн цэгт зөөж зайлуулах, тээвэрлүүлэх	Төслийн хэмжээнд	Тогтмол	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр. Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.		“Мөнх ариун ундарга” ХХК	Налайх дүүргийн ТҮК	Гэрээний дагуу зөвшөөрсөн цэгт зөөж зайлуулдаг байх	
	Аялал жуулчлалын улирал дуусах үед эдэлбэр газар, түүний эргэн тойрны хариуцан хамгаалах талбайн цэвэрлэгээг хийх	Төслийн хэмжээнд	Жилд 1-ээс доошгүй удаа	200,000	200,000	“Мөнх ариун ундарга” ХХК		Хариуцсан хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгөх	
Үйл ажиллагаанаас гарах ахуйн хатуу хог хаягдал	Өрөө, гэрт хог хаягдлыг ангилан ялгах боломжтой хогийн сав байрлуулах	Өрөө, гэрт	4 ш	25,000	100,000	“Мөнх ариун ундарга” ХХК			
	Хог хаягдлыг ангилах талаар мэдээллийн самбар байрлуулах	Төслийн хэмжээнд	2ш	50.000	100.00	“Мөнх ариун ундарга” ХХК			
Хатуу хог хаягдлыг ил задгай, зориулалтын бус цэгт хаях	Хог хаягдлын талаар амрагч, ажилчдад мэдээлэл түгээх, танилцуулга хийх	Амрагч, ажилчид	Жилд 1 удаа	100,000	100,000	“Мөнх ариун ундарга” ХХК			
Ялаа шавж үржих, өвчин гарах	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлж ойр орчмыг тогтмол цэвэрлэж байх	Хатуу хог хаягдлын цэгт	Улирал бүр тогтмол, жилд 2 удаа	25,000	50,000	“Мөнх ариун ундарга” ХХК			

Удаан затардаг хатуу хог хаягдал үүсэх	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Төслийн хүрээнд	Тухай бүрд нь	Зардал тусгах шаардлагагүй.	“Мөнх ариун ундарга” ХХК	Гэрээ байгуулж ажиллах		
Нийт зардал: 3,050,000								

5.1.1. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргадаг ба уг төслийн хувьд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй болно.

5.1.2. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тус төслийн талбай нь Улаанбаатар хот Налайх дүүрэг 6-р хороо , Горхи-Тэрэлж байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд байрладаг. Төслийн талбай нь бусад газар ашиглагч нарын зөвшөөрөл бүхий газартай давхцалгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгөөгүй болно.

5.1.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тус төслийн талбай орчимд одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай.

5.1.4. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Энэхүү төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд тусгалаа.

5.2. Осол, эрсдэлийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Осол, эрсдэлийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул сөрөг нөлөөллүүд	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, төг	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэл-тийн шалгуур Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8	9
Гэнэтийн болзошгүй осол эрсдэл									
1	Газар хөдлөлт	Зохих зураг төслийн стандартыг ашиглан гүйцэтгэгч байгууллагад шаардлага тавих, байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгөх	Төслийн талбай	ш удаа	1	-	-	1 удаа	Монголын засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”
2	Аянга цахилгаан	Аянга зайлуулагчийг ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах. ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх	Төслийн талбай	Ш удаа	1	-	-	1 удаа	Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын ажлын аюулгүй ажиллагааны дүрэм
3	Аадар бороо	Барилга байгууламжуудын зураг төсөл, чанарт цаг агаарын нөхцөлүүдийг тусгах, үерээс хамгаалсан далан байгууламжтай болгох	Төслийн талбай	Иж бүрэн	-	-	-	1 удаа иж бүрэн	
4	Шороон шуурга	Онцгой байдлын журам боловсруулан мөрдөж ажиллах	Төслийн талбай	-	тогтмол	-	-	Тогтмол	
5	Халдварт өвчин	Өндөр эрсдэлтэй амьтадтай (шувууд) харьцахгүй байх хангалттай хэмжээний хамгаалалтын хэрэгсэлтэй байх (амны хаалт гэх мэт)	Төслийн талбай	Боодол	10	-	-	тогтмол	
6	Химийн аюултай бодис асгарах	Ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай	Төсөл хэрэгжих бүс нутаг	-	Тогтмол	-	-	тогтмол	
Нийт: -									

5.3. Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7. Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, өртөгч	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээн ий цар, хэмжээ	Тоо хэмжээ (5 жилээр)	Урьдчилан тооцсон төсөв, төгрөг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Байгаль орчны удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээ								
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил бүр батлуулж байх		Төслийн хүрээнд	Жил бүр	-	“Мөнх ариун ундарга” ХХК		БОМТ-нд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	
Ажилчдын дунд байгаль хамгаалах талаар сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах - Байгаль орчныг хамгаалах - Гал түймрээс урьдчилан сэргийлэх /шаардлагатай үед гал унтраах багаж хэрэгслийг ашиглаж чаддаг байх/ - Хөдөлмөр хамгаалал		Бүх ажилчид	Жилд 1 удаа	100.000	“Мөнх ариун ундарга” ХХК	Байгаль орчны мэргэжилтний оролцоотойгоор	Сургалтад хамрагдсан бүртгэл тэмдэглэл	
Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх		Төслийн хүрээнд	1 ш	-	“Мөнх ариун ундарга” ХХК			
Орон нутгийн засаг захиргаа, тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, хорооны иргэдийн саналыг сонсож, зохих арга хэмжээ авах, харилцан мэдээлэл солилцож байх		Төслийн хүрээнд	Орон нутгийн иргэдийн санал хүсэлттэй холбоотой	Тухайн үеийн үйл ажиллагааны зардалд тусгагдана.	“Мөнх ариун ундарга” ХХК		Хурал уулзалтаас гарсан шийдвэр	БОНХЯ-ны сайдын 2014.01.06-ны өдрийн А-03 тоот журам
Төслийн талбай орчмын иргэдийн санал хүсэлтийг харгалзан тулгамдаж буй асуудлыг шийдэхэд дэмжиж туслах		Төслийн хүрээнд	Хорооны иргэдэд тулгамдаж буй асуудлууд, тусгай хамгаалалттай	Санал хүсэлттэй холбоотой	“Мөнх ариун ундарга” ХХК	Хорооны ЗДТГ	Тулгамдаж буй асуудлуудаас	БОНХЯ-ны сайдын 2014.01.06-ны өдрийн А-03 тоот журам

		газар нутгийн хамгаалалтын захиргааны санал				шийдвэрлэсэн байх	
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах		Төслийн хүрээнд			“Мөнх ариун ундарга” ХХК		“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003
Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ дүүргийн ТҮК-тэй хийсэн гэрээний дагуу зайлуулах		Төслийн хүрээнд			“Мөнх ариун ундарга” ХХК		“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003
Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөрийг төлөх		Төсөвт хувь нэмэр оруулах	5 багц	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.	“Мөнх ариун ундарга” ХХК		Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон бусад
Эрүүл мэндийг хамгаалах	Ажлын байранд эмийн сан бий болгох	Иж бүрэн	5	60.000	“Мөнх ариун ундарга” ХХК		
Нийт зардал: 160,000							

5.4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал (.төг)	Нийт зардал /1 жилээр/ (.төг)	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах стандарт
1. АГААРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
1.1.	Хорт хийн агууламж: Азотын давхар исэл (NO ₂) Хүхэрлэг хий (SO ₂) Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO ₂), CO, HCN, O ₂ .	мкг/м ³	Хатуу хог хаягдлын цэг авто машины зогсоолын ойролцоо	Жилд 2 удаа	50,000	200,000	“Мөнх ариун ундарга” ХХК	Мэргэжлийн байгууллага, судлаач	MNS 4585:2016. MNS 3384:1982. MNS 4048:1988. MNS 0017-2-5-11:1988. MNS 5013:2009. MNS 5014:2009. MNS 5002:2000.
1.2.	Агаарын тоосонцор (PM _{2.5} , PM ₁₀)	мкм	Хатуу хог хаягдлын цэг авто машины зогсоолын ойролцоо		50.000	200.000	“Мөнх ариун ундарга” ХХК		
1.3.	Цацрагийн хэмжилт		Үнс хадгалах цэгээс	Жилд 2 удаа	50.000	100.000	“Мөнх ариун ундарга” ХХК		
1.4	Уурын зуухны яндангаас гарах хийн хаягдлын хэмжээ		Уурын зуухны ойролцоо	Жилд 2 удаа	50.000	100.000	“Мөнх ариун ундарга” ХХК		
2. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
2.	Усны химийн шинжилгээ Био идэвхт нэгдлүүд Нян судлалын үзүүлэлт: Нянгийн тоо Гэд+3000эсний бүлгийн савханцар Эмгэг төрөгч бактери Cl.perferringens	мг/дм ³	Унд-ахуйн зориулалтаар хэрэглэгдэж буй ус	Жилд 2 удаа	80,000	160,000	“Мөнх ариун ундарга” ХХК	Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн усны лаборатори, Ус цаг уур орчны шинжилгээний газар	MNS (ISO) 5667-1:2002 MNS (ISO) 5667-2:2002: MNS 4867-1999: УСТ-3534-1983 MNS 0900:2005 MNS 4685:1998
		1 мл-т илрүүлэх 100 мл-т							
3. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал (.төг)	Нийт зардал /1 жилээр/ (.төг)	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах стандарт
3.1.	Хөрсний физик, агрохимийн үндсэн үзүүлэлтүүд: Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O)	мг	Хатуу хог хаягдлын цэг Ногоон байгууламжийн ойролцоо	Жилд 2 удаа	70,000	140,000	“Мөнх ариун ундарга” ХХК	Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори, Магадлан итгэмжлэгдсэн хөрсний лабораториуд	MNS 3298:1991. MNS 5850:2008. MNS 3985-87. MNS 3310-91. MNS 2305-94. MNS 2305:1994.
3.2.	Хөрсний хүнд элементүүд /Pb, Cr, Cd, Ni, Co/		Хатуу хог хаягдлын цэг Авто зогсоолын ойролцоо	Жилд 2 удаа	80,000	160,000	“Мөнх ариун ундарга” ХХК		
ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ									
4	Дуу шуугиан	дБА	Баазын талбай орчимд	Жилд 2 удаа	50,000	200,000	“Мөнх ариун ундарга” ХХК	Сумын эрүүл мэндийн байгууллага	MNS 5002:2000 MNS ISO 226:2003
1 жилийн ОХШХ-ийн нийт зардал						1,260,000			

5.5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ							“БОНХЯ-ны сайдын 2014.01.06-ны өдрийн А-03 тоот журам” Олон нийтийн оролцоо, хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Хэрэгжүүлэгч	
БОУАӨЯ, ХБӨБХГ	Шинжээчдийн дүгнэлтээр баталгаажна.	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан	Жил бүрийн 11-р сарын 1-ний дотор	Шинжээчдийн дүгнэлт	Дүүргийн байгаль орчны газар	“Мөнх ариун ундарга” ХХК	
Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч	Хуралд танилцуулах, Уулзалт	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	12-р сарын 1-ний дотор	БОХ арга хэмжээний тайлан, ирэх оны төлөвлөгөөг танилцуулах, санал авах, хамтран ажиллах	Дүүрэг, Нийслэл	“Мөнх ариун ундарга” ХХК	
Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, төрийн бус байгууллагууд, олон нийт			Жил бүр 1 удаа		Тухайн үед сонгох	“Мөнх ариун ундарга” ХХК	
Төрийн захиргааны төв байгууллага	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр		12-р сарын 10-ний дотор	Хянуулах батлуулах	Улаанбаатар хот	“Мөнх ариун ундарга” ХХК	

5.6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний 2025 оны зардлыг дараах хүснэгтэд харуулав.

Зардлын хэлбэр	Нийт зардал, төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	400,000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	3,050,00
Осол, эрсдэлийн төлөвлөгөөний зардал	-
Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	160,000
БОМТ-г хэлэлцүүлэх, тайлагнах зардал	-
Орчны хяналт шинжилгээний зардал	1,260,000
Нийт	4,870,000

“Мөнх Ариун Ундарга” ХХК-ийн “Сац аялал жуулчлалын бааз” төслийн 2025 оны тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **4,870,000** (Дөрвөн сая найман зуун далан мянга) төгрөг болж байна.

6. ДҮГНЭЛТ

“Мөнх Ариун Ундарга” ХХК-ийн “Сац аялал жуулчлалын бааз” төсөл нь Улаанбаатар хот Налайх дүүрэг 6-р хорооны нутагт хэрэгжиж байна. Төслийг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулж буй “Мөнх Ариун Ундарга” ХХК нь тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **4,870.000** төгрөг зарцуулагдах урьдчилсан дүн гарсан байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн бичиг баримт юм.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор төсөл хэрэгжүүлж байгаа БОУАӨЯ, аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлэх шаардлагатай.